

Архины хэрэглээний төвшинг шалгах тест

2010-02-19 12:01 GMT+8

Зохистой хэрэглээ гэж юу вэ?

Стандарт уултын хэмжээ нь хүний элэгний хоргүйжүүлэх үйл ажиллагаатай уялдаатай бөгөөд насанд хүрсэн хүний эрүүл элэг 1 цагт 10 гр архи /этанол/-г задлан хоргүйжүүлж, энэ нь 10-11 цагийн дараа бүрэн гүйцэт задран биеэс гадагшилдаг.

Стандарт уултын хэмжээ:

Архи	25 мл
Пиво	250 мл
Дарс	100 мл
Ликёр	60 мл

Эдгээрийг тус тусад нь **1 стандарт (ст)** гэж үзэх бөгөөд тус бүрийн найрлаганд агуулагдах цэвэр спирт буюу этанолын хэмжээ 10 гр байна.

1 удаад: * Эрэгтэйчүүд 3 ст,
* Эмэгтэйчүүд 2 ст

уултаас хэтрүүлж хэрэглэхгүй бол архины хамааралд өртөхгүй байж чадна.

Хэрэв

7 хоногт: * Эрэгтэйчүүд 21 ст,
* Эмэгтэйчүүд 14 ст

уулт болон түүнээс ихээр хэрэглэвэл архины хамааралд өртөнө.

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ ТҮВШИНГ ШАЛГАХ ТЕСТ

1. Та согтууруулах ундааг хир давтамжтай хэрэглэдэг вэ?

(0) Огт хэрэглэдэггүй

(1) Сард 1 удаа ба түүнээс бага

- (2) Сард 2-4 удаа
- (3) Долоо хоногт 2-3 удаа
- (4) Долоо хоногт дор хаяж 4 удаа

2. Та согтууруулах ундааг хэдэн стандарт уултаар хэрэглэдэг вэ?

- (0) 1 эсвэл 2
- (1) 3 эсвэл 4
- (2) 5 эсвэл 6
- (3) 7, 8 эсвэл 9
- (4) 10 эсвэл түүнээс дээш

3. Нэг удаагийн уултаар 6 болон түүнээс дээш стандарт хэмжээгээр ууж байсан удаа бий юу?

- (0) Үгүй
- (1) Сар болгон биш
- (2) Сардаа
- (3) Долоо хоногтоо
- (4) Өдөр болгон

4. Өнгөрсөн жилийн дотор та согтууруулах ундааг ууж эхэлсэн тохиолдолд зогсоож чадахгүй байсан удаа бий юу?

- (0) Үгүй
- (1) Сар болгон биш
- (2) Сардаа
- (3) Долоо хоногтоо
- (4) Өдөр болгон

5. Өнгөрсөн жилийн дотор та согтууруулах ундааг хэрэглэснээс болж өөрийн хийх ёстой юмыг хийж чадахгүй байсан удаа бий юу?

- (0) Үгүй
- (1) Сар болгон биш
- (2) Сардаа
- (3) Долоо хоногтоо
- (4) Өдөр болгон

6. Өнгөрсөн жилийн дотор та урьд өдөр нь уусан тохиолдолд маргааш өглөө хэвийн байдалд орохын тулд архи хэрэглэж байсан удаа бий юу?

- (0) Үгүй
- (1) Сар болгон биш

- (2) Сардаа
- (3) Долоо хоногтоо
- (4) Өдөр болгон

7. Өнгөрсөн жилийн дотор танд уусны дараа гэмшил төрж байсан удаа бий юу?

- (0) Үгүй
- (1) Сар болгон биш
- (2) Сардаа
- (3) Долоо хоногтоо
- (4) Өдөр болгон

8. Өнгөрсөн жилийн дотор та урьд өдөр нь согтуудаа болсон юмыг санахгүй тохиолдол байсан уу?

- (0) Үгүй
- (1) Сар болгон биш
- (2) Сардаа
- (3) Долоо хоногтоо
- (4) Өдөр болгон

9. Та согтууруулах ундааг хэрэглэснээс болж бусад хүмүүст эсвэл өөртөө хохирол учруулж байсан удаа бий юу?

- (0) Үгүй
- (2) Тийм гэхдээ өнгөрсөн жилд биш
- (4) Тийм, өнгөрсөн жилд

10. Таны гэр бүл, хамаатнууд, найзууд эсвэл эмч таны архины хэрэглээний талаар санаа зовж архиныхаа хэрэглээг зогсоох шаардлагатай гэж хэлж байсан уу?

- (0) Үгүй
- (2) Тийм гэхдээ өнгөрсөн жилд биш
- (4) Тийм, өнгөрсөн жилд

Оноо тайлбар

Оноо	Үйлчлүүлэгч			
	0-7	8-15	16-19	20-40
	I	II	III	IV
Архины хэрэглээний түвшин	Согтууруулах ундаа огт хэрэглэдэггүй буюу Эрсдэл багатай архины хэрэглээтэй	Архи хэтрүүлэн хэрэглэгч буюу Аюултай хэрэглээтэй	Архи хэтрүүлэн хэрэглэгч буюу Хортой үр дагавар өгөхүйц хэрэглээтэй	Архины хамааралтай
Авах арга хэмжээ	Архины хэрэглээний талаар мэдлэг олгох	<ul style="list-style-type: none"> • Энгийн зөвлөгөө • Архины хэрэглээний талаар мэдлэг олгох 	<ul style="list-style-type: none"> • Энгийн зөвлөгөө • Богино хугацааны ярилцлага • Хяналтанд авах 	<ul style="list-style-type: none"> • Аддиктологийн нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө • Хяналтанд орох

АНХААР! Та сэтгэгдэл бичихдээ хууль зүйн болон ёс суртахууныг баримтална уу. Ёс бус сэтгэгдлийг админ устгах эрхтэй. Мэдээний сэтгэгдэлд GoGo.mn хариуцлага хүлээхгүй.